БАТЛАВ.
УЛААНБААТАР ДУЛААНЫ
СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Р.ХАЙДАВ
.....................................................
/Гарын үсэг, тамга/

БАТЛАВ.
.....................................................
/Гарын үсэг, тамга/

**ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧИЙГ**
**ХУДАЛДАХ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ**

2014 оны 10 сарын 14 -ны өдөр № 872 Улаанбаатар хот

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү гэрээг нэг талаас УБДС ТӨХК-ийг төлөөлж Дулааны үйлчилгээний ... /дүгээр/, /дугаар/ салбарын дарга ...................... /цаашид худалдагч гэх/, нөгөө талаас .................................. ХХК-г төлөөлж ........................ албан тушаалтай ............................ /цаашид худалдан авагч гэх/ нар Иргэний хууль, Эрчим хүчний тухай хууль, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм, Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрмийг тус тус үндэслэл болгон дараах нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.

1.2. Энэхүү гэрээгээр дулааны эрчим хүчийг гэрээнд заасан тоо, чанарын түвшинд худалдах /халаалт, хэрэглээний халуун ус, салхивч болон технологийн халуун ус/ эрчим хүч хэрэглэсний төлбөрөө тогтоосон хугацаанд бүрэн төлөх, талууд харилцан эрх эдлэж, үүрэг хүлээх, хариуцлага хүлээлгэх, хэрэглэгчийг эрчим хүчээр хангахтай холбоотойгоор хангагч талаас тавих технологийн горимтой холбоотой шаардлагыг хэрэглэгч тал хханган биелүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

## Хоёр. Худалдагч талын эрх, үүрэг

### 2.1. Худалдагч талын эрх

2.1.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг хэрэглэгчээс шаардах, дулааны эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд албан шаардлага, мэдэгдэх хуудас өгөх, төлбөр нэхэмжлэх, гэрээ цуцлах, эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлэх, зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах;

2.1.2. Худалдагч тал горимын тооцоог үндэслэн худалдан авагчийн шугамнаас бусад хэрэглэгчийг холбох;

2.1.3. Дулааны эрчим хүчийг зүй бусаар хэрэглэсэн хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээг нөхөн тооцох, төлбөрийг нэхэмжлэх;

2.1.4. Худалдагч талын эрх бүхий ажилтнууд нь ажлын шаардлагаар хэрэглэгч талын дулаан хангамжийн хэмнэлттэй, найдвартай ажиллагаа болон тохируулга, тооцооны хэрэгслийн хэвийн байдалд үзлэг шалгалт хийх мөн түүнчлэн хэрэглэгч талын дулааны шугам, тоног төхөөрөмж нь технологи ажиллагааны шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор барилга байгууламжид 24 цагийн аль ч үед нэвтрэх;

2.1.5. Хэрэглэсэн эрчим хүчнийхээ төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй хэрэглэгчтэй байгуулсан дулааны эрчим хүч худалдах, худалдан авах гэрээг цуцлаж, эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлэх, дулааны шугам сүлжээний хамгалаалалтын зурваст хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулсан хэрэглэгчийг дулааны эрчим хүчээр хангахаас татгалзах;

2.1.6. Дулааны тоолуур, хэмжих хэрэгсэл түүний битүүмжлэл, лац ломбо, холболтыг дураар өөрчилж, хэвийн ажиллагааг алдагдуулсан, зохих зөвшөөрөлгүйгээр, дур мэдэн өөр хэрэглэгчийг эрчим



хүчээр хангасан, хангагчийн эрх бүхий ажилтныг өөрийн барилга байгууламжид нэвтрэх боломж олгоогүй, дулаан хангамжийн хэвийн ажиллагааг алдагдуулах үйлдэл гаргасан зэргээс шалтгаалан тухайн зөрчил гаргасан хэрэглэгчийн дулааны эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлэх эрхтэй.

### 2.2. Худалдагч талын үүрэг

2.2.1. Энэхүү гэрээнд заасан хугацаанд хэрэглэгчийг дулааны эрчим хүчээр тасралтгүй хангах; /Дулааны төв шугамд төлөвлөгөөт нягтын шахалт, засвар хийхээр хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд зарласан хугацаа үүнд хамаарахгүй./

2.2.2. Дулааны эрчим хүчээр хангахдаа Диспетчерийн үндэсний төвөөс тогтоосон горим, параметрийг мөрдөж ажиллах;

2.2.3. Худалдагч тал нь дулаан дамжуулах төв шугамын төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус таслалтын тухай хэрэглэгчдэд дараах журмаар мэдээлнэ. Үүнд:

2.2.3.1. Худалдагч нь дулаан дамжуулах төв шугамын туршилт, нягтын шахалт, ээлжит засварын ажлыг эрх бүхий байгууллагын баталсан графикийн дагуу явуулах бөгөөд уг төлөвлөгөөт таслалтын хугацааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд урьдчилан мэдээлэх;

2.2.3.2. Дулаан дамжуулах төв шугамд гарсан эвдрэл, гэмтлийн улмаас хэрэглэгчдийг дулаанаар хангах боломжгүй нөхцөл үүссэн үед хангагч тал үүссэн нөхцөл байдал, түүний үргэлжлэх хугацааны тухай хэрэглэгчдэд нэн даруй мэдэгдэх;

2.2.4. Худалдагч тал худалдан авагч талын дулааны шугам, тоног төхөөрөмжид хийх шаардлагатай засвар үйлчилгээний талаар зөвлөмж болон шаардах хуудас, албан бичгийг гэмтэл гарсан үед нь тухай бүр өгөх бөгөөд дараа оны 4, 5 дугаар саруудад засварын шаардах

хуудсыг худалдан авагч талд өгч, засвар үйлчилгээний гүйцэт- гэлд нь батлагдсан графикт зогсолттой уялдуулан хяналт тавих;

2.2.5. Худалдагч тал дулаан хангамжийн талаарх худалдан авагч талын гаргасан санал, гомдлыг хүлээн авснаас хойш шуурхай бараг-дуулах ба ажлын 5 хоногт багтаан хариуг өгөх;

2.2.6. Худалдагч тал дулаанаар хангагдах техникийн нөхцөл хүсч, худалдагч талд хэрэглэгчээс ирүүлсэн өргөдлийг техникийн нөхцөл олгох комиссын хуралдаанаар шийдвэрлэж хариуг өгөх;

2.2.7. Худалдагч тал нь зөвхөн худалдан авагч талын захиалсан хэмжээгээр дулааны эрчим хүчийг худалдах ба гэрээнд өөрчлөлт оруулах тохиолдолд албан бичиг, горимын тооцоог үндэслэн шийд-вэрлэх;

2.2.8. Дулааны эрчим хүчний үнэ тариф болон үйлчилгээний төл-бөр хураамжид өөрчлөлт орвол мөрдөж эхлэхээс 15 хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэрэглэгчдэд мэдэгдэх үүрэгтэй.

## Гурав. Худалдан авагч талын эрх, үүрэг

### 3.1. Худалдан авагч талын эрх

3.1.1. Стандартын шаардлага хангасан дулааны эрчим хүчээр хангагдах;

3.1.2. Хангагчийн үйл ажиллагааны талаар компанийн удирдах албан тушаалтанд мэдээлэх, санал хүсэлт, өргөдөл гомдол гаргаж шийдвэрлүүлэх;

3.1.3. Худалдан авагч тал нь худалдагч тал гэрээгээр хүлээсэн үүргээ тасалдуулсан буюу гэрээнд заасан тоо хэмжээ чанарын үзүү-лэлт бүхий дулаанаар хангаагүй бол худалдан авагч тал төлбөрийн зарим хэсгийг төлөхөөс татгалзах, учирсан хохирлоо нөхөн төлүү-лэхээр нэхэмжлэх;



3.1.4. Техникийн зайлшгүй шалтгаанаар гэрээнд заасан хугацаа-наас хойш дулаан авах, хугацаанаас өмнө дулаан хангамжийг хаах бол энэ тухайгаа худалдагч талд 7-оос доошгүй хоногийн өмнө албан ёсоор мэдэгдэж, худалдагч талын төлөөллийг байлцуулан гүйцэтгэнэ. Энэ үед гэрээний эх үүсвэрт өөрчлөлт орвол тухайн сарын тооцоонд тусгуулах;

3.1.5. Худалдагч талаас худалдан авагчид урьдчилан мэдэг-дэлгүйгээр дулаан хангамжийг тасалдуулсан, сүлжээний усны пара-метрийг гэнэтийн хэлбэлзэлд оруулсан, худалдагч талын ажилтны гаргасан алдаа, хайхрамжгүй үйлдлийн улмаас хэрэглэгчийн шугам, тоног төхөөрөмжид гэмтэл гарч хохирол учирсан бол хохирлын хэм-жээг тооцсон актыг үндэслэн худалдагч талаас нэхэмжлэх;

3.1.6. Худалдан авах дулааны тоо хэмжээг гэрээнд заагдсанаас нэмэгдүүлэх буюу багасгах тухай хүсэлтийг худалдагч талд гарган шийдвэрлүүлэх;

3.1.7. Дулаан хангамжийн найдвартай байдлын түвшинг ахиу-лах хүсэлтээ хангагчид тавьж шийдвэрлүүлж болох бөгөөд холбогдох зардлыг хэрэглэгч хариуцна.

### 3.2. Худалдан авагч талын үүрэг

3.2.1. Хэрэглэгч нь дулааны эрчим хүчний төлбөрөө сар бүрийн 25-ны дотор төлж, өр төлбөр үүсгэхгүй байх;

3.2.2. Худалдан авагч тал өөрийн өмчлөл, эзэмшлийн дулааны шугам, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангаж, дулааны эрчим хүчний техник ашиглалтын болон аюулгүй ажиллагааны дүр-мийг мөрдөж ажиллахаас гадна суурилагдсан дулаан хангамжийн тоног төхөөрөмжийн тохируулга, тооцоолол, хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдал ба хэвийн ажиллагааг хангахын зэрэгцээ дулааны шугамын буцах усны температурыг зөвшөөрөгдөх хэмжээнд барих;

3.2.3. Худалдан авагч нь өөрийн өмчлөл, эзэмшил бүхий дулааны шугам, тоног төхөөрөмжид дулаан хангамжийн горимд нөлөөлөхүйц гэмтэл саатал гарвал худалдагч талд нэн даруй мэдэгдэж үндсэн сүлжээнээс тусгаарлах арга хэмжээ авах бөгөөд өндөр даралт, температурт ажилладаг дулааны шугам, тоног төхөөрөмжийг жил бүр заавал угааж, шахаж, шалган аюулгүй, найдвартай ажиллагааг хангах;

3.2.4. Хэрэглэгч нь дулаан хангамжийн системийг халаалтын улирлын эхэнд төвлөрсөн дулаан хангамжид залгах үед */халаалтын системийн тохируулга, згшрүүлэг, дүүргэлттэй холбогдон/* гарсан нэмэгдэл зардлыг хариуцах бөгөөд уг төлбөрийг худалдагч талын тогтоосон аргачлалаар тооцож нэхэмжилсэн дүнгээр халаалтын улирал эхлэхийн өмнө жилд нэг удаа төлөх;

3.2.5. Худалдагч талаас өгсөн зөвлөмж, тавьсан шаардлагыг биелүүлээгүйн улмаас өвлийн оргил ачааллын үед шугам, тоноглолд гэмтэл гарч, худалдагч талд болон төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон бусад хэрэглэгчдэд хохирол учруулбал уг хохирлыг хариуцаж барагдуулах;

3.2.6. Худалдан авагч нь худалдагч талаас олгогдсон техникийн нөхцлийн дагуу бусад хэрэглэгчийг өөрийн өмчлөл, эзэмшлийн дулааны шугамнаас саадгүй холбуулах, өөрийн эзэмшлийн барилга байгууламжийн талбай, эзлэхүүн, хүний тоо, тоолуууртай, тоолуургүй эх үүсвэрийн хэмжээ зэргийг үнэн зөв мэдүүлж гэрээнд тусгуулах үүрэг хүлээх;

3.2.7. Худалдан авагч нь өөрийн газарт барилга обьект төвлөрсөн дулаан хангамжид шинээр холбогдвол гидравлик тооцооны дүнд нийцүүлэн худалдагч талын зөвшөөрлөөр шугамыг өргөтгөх, бойлерын хүчин чадлыг нэмэгдүүлэх, тохируулах хэрэгсэл тавих, заагийн зургаа шинэчлэн баталгаажуулж, төлбөр тооцоо хийлгэх;

3.2.8. Худалдан авагч тал нь дулааны шугам, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээ хариуцсан мэргэжлийн слесарь ажиллуулах ба дулааны үндсэн зангилааны дараах хэлхээний /2-р контур/ тооцоо, тохируулгыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэж, худалдагч байгууллагаар хянуулах;

3.2.9. Худалдан авагч талын хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны чиглэл, хаяг, харилцах банк, дансны дугаар, үл хөдлөх хөрөнгийн эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд ажлын 5 хоногийн дотор худалдан авагч тал худалдагч талд албан ёсоор мэдэгдэж, уг өөрчлөлтийг гэрээнд тусгуулах;

3.2.10. Худалдан авагч нь дулааны эрчим хүч хэрэглэх барилга байгууламжийн талаар хүснэгт №1-ийн дагуу үнэн зөв гаргаж мэдүүлэх үүрэгтэй бөгөөд захиалгат дулааны эрчим хүчний тоо хэмжээг өөрчлөх шаардлага гарвал тухай бүр хүсэлт тавьж гэрээнд өөрчлөлт оруулах;

3.2.11. Дулааны эрчим хүчний үнэ тарифт өөрчлөлт оруулсан тухай олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлан мэдэгдсэнээс хойш 15 хоногийн дотор худалдан авагч нь худалдагч талтай байгуулсан гэрээнд зохих өөрчлөлийг оруулах;

3.2.12. Дулаан хангамжид холбогдсон барилга байгууламжийг өөрийн өмчлөлд шилжүүлэн авч байгаа хэрэглэгч нь уг обьектийг шилжүүлэн өгч буй этгээд дулааны эрчим хүч хэрэглэсний төлбөр, өр зээлийн үлдэгдэлтэй эсэх талаар худалдагч байгууллагаас магадлах үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаварыг бүрэн хариуцна.

3.2.13. Дулааны эрчим хүч хэрэглэхтэй холбогдуулж хэрэглэгч талын үйл ажиллагаанд хориглох зүйлүүд. Үүнд:

3.2.13.1. Худалдагч талын зөвшөөрөлгүйгээр дулааны тоноглол, барилгын талбай, эзлэхүүнийг нэмэгдүүлэх, холболтыг өөрчлөх, нэмэлт холболт хийх;

3.2.13.2. Халаалт дулаацуулгын системийн усыг өөр зориулалтаар ашиглах, зүй бус хэрэглэхийг хориглоно.

*Хүснэгт №1*

Гэрээнд тусгагдах эх үүсвэр

| Барилга объектын нэр | Халаалт | | | Хэрэгцээний халуун ус | | | Салхивч /гкал/ | Дулааны тоолууртай эсэх | Өрхийн тоо | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Эзэлхүүн /м³/ | Орон сууцны талбай /м²/ | Подвал /м²/ | Албаны /хүнээр/ | Орон сууцны /хүнээр/ | Хэрэгцээний халуун ус | | | 40м² хүртэл | 41-80 м² | 81м² дээш |
| ЗӨСҮТөв | 11051,4 | | | | | 99,9 | | ХЯ1655 | | | |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| Нийт | | | | | | | | | | | |



## Дөрөв. Дулааны эрчим хүчний төлбөр тооцооны журам

4.1. Талууд хоорондын дулааны эрчим хүчний төлбөр тооцоонд “Эрчим хүчний зохицуулах хороо”-ны Зохицуулагчдын зөвлөлөөс баталсан тарифыг хэрэглэх бөгөөд хэрэв энэ тарифыг шинэчлэн тогтоосон бол мөрдөж эхлэхээр нийтэд зарласан өдрөөс эхлэн төлбөр тооцоонд мөрдөнө.

4.2. Дулааны тоолууртай хэрэглэгчийн хувьд харилцан тохиролцсоны үндсэн дээр захиалгат дулааны эрчим хүчний төлбөрийг төлж, дулааны эрчим хүч хэрэглэнэ.

4.3. Дулааны төлбөр тооцоог талбай, эзлэхүүн, хүчин чадлаар хийх тохиолдолд худалдагч тал сарын эхний 10 хоногт багтаан нэхэмжлэл бичиж худалдан авагчид хүргүүлэх ба худалдан авагч төлбөрийн нэхэмжлэх бичигдсэн өдрөөс хойш 14 хоног буюу тухайн сарын 25-ны дотор төлнө.

4.4. Дулааны төлбөр тооцоог тоолуураар хийж байгаа тохиолдолд тухайн сард авах дулааны эрчим хүчний үнийн 50-иас доошгүй хувийн урьдчилгаа төлбөрийг тухайн сарын эхний 14 хоногт багтаан төлнө. Үлдэгдэл төлбөрийг худалдагч талаас ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэхийг үндэслэн тухайн сарын 25-ны дотор төлнө.

4.5. Хэрэглэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй болон хэрэглэгчийн буруутай үйл ажиллагаатай холбоотой дараах зөрчлүүдэд худалдагч тал нэмэлт ба нөхөн төлбөр, торгууль, алданги ногдуулж төлүүлнэ. Үүнд:

4.5.1. Хэрэглэгч сүлжээний буцах усны халууныг батлагдсан графикаас 4-өөс дээш градсаар өндөржүүлсэн тохиолдолд өндөржүүлсэн градуст ноогдох ашиглахгүй буцаасан дулааны үнийг тухайн сарын төлбөр дээр нэмж тооцно.

4.5.2. Шугам тоноглолд эвдрэл гэмтэл гарсан болон сүлжээний усыг өөр зориулалтаар ашигласнаас усны алдагдал гаргасан тохиол-

долд илүү зарцуулсан дулаан ба нэмэлт усаар түгээсэн дулааныг тооцож тухайн сарын төлбөр дээр нэмж ногдуулна.

4.5.3. Хэрэглэгч нь эзэмшлийн заагаар өөрийн хэсэгт тавигдсан дулааны тоолуур, хэмжих хэрэгслийн эд анги, битүүмжлэл, байрлал, холболтыг дур мэдэн өөрчилсөн буюу хэвийн ажиллагааг алдагдуулсан болон, тоолуур гэмтэлтэй байгаа нь тогтоогдвол төлбөр тооцоог худалдагч тал уг барилга объектын зураг төслөөр тооцсон хүчин чадлыг үндэслэн проектийн ачааллаар тооцон төлүүлэх бөгөөд холбогдох иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд Эрчим хүчний тухай хуулийн дагуу торгууль ногдуулна.

4.5.4. Худалдан авагч нь гэрээнд зааснаас өөр зориулалтаар дулааны эрчим хүчийг зүй бусаар хэрэглэсэн, орон сууцны барилгын зориулалтыг өөрчилсөн буюу өргөтгөл барьж аж ахуйн үйл ажиллагаа явуулж буй хэрэглэгчийг төвлөрсөн дулаан хангамжийн системд худалдагч талын зөвшөөрөлгүйгээр холбосон, хүний тоог бууруулсан нь худалдагч талын шалгалтаар илэрвэл, зүй бусаар хэрэглэж эхэлсэн хугацаа тодорхойгүй бол тухайн халаалтын улирлын туршид дулааны эрчим хүч хэрэглэснээр тооцож, нөхөн төлбөр тавьж, Эрчим хүчний тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу арга хэмжээ авна.

4.5.5. Худалдан авагч нь хэрэглэсэн дулааны эрчим хүчний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй буюу дутуу төлсөн бол худалдагч тал хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувиар, төлвөл зохих төлбөрийг 2 буюу түүнээс дээш сарын хугацаагаар төлөөгүй буюу дутуу төлсөн бол гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувиар тус тус алданги ногдуулна. Алдангийг сар бүрийн төлбөрт тус тусад нь ногдуулах бөгөөд алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй байна.

4.5.6. Хэрэглэгчийн шугамын дулааны алдагдлыг 5 хувиар тооцож, сар бүрийн хэрэглэсэн дулааны төлбөр дээр нэмж тооцно.



4.5.7. Хэрэв хэрэглэгч бэлнээр тооцоог хийх бол банкин дахь худалдагчийн дансанд эсвэл бэлэн мөнгөний кассанд биечлэн тушааж, мөнгө тушаасан баримтыг авч хадгална. */Гуравдагч этгээдээр дамжуулан тушаасан мөнгөтэй холбогдсон маргаантай асуудлыг худалдагч тал хариуцахгүй/.*

4.6. Талуудын хооронд тавигдах нэмэлт ба нөхөн төлбөр, торгууль, хохирлын нэхэмжлэлийг тушаахдаа талууд хамтран тогтоосон актыг үндэслэн гүйцэтгэнэ.

4.7. Талууд жилд 2-оос доошгүй удаа дулааны эрчим хүчний борлуулалтын төлбөрийн талаар тооцоо нийлж, акт үйлдэх бөгөөд жил бүрийн халаалтын улирал дуусахад хангагч талын “Төлбөр тавилтын түүх”-ийг үндэслэн гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулна.

4.8. Худалдан авагч нь тухайн сарын дулааны төлбөрийг дараах хуваарийн дагуу төлж барагдуулна.

*Хүснэгт №2*

| Төлбөр төлөх хугацаа | Сар бүрийн | | |
|---|---|---|---|
| | 15-ны дотор | 20-ны дотор | 25-ны дотор |
| Төлөх хэмжээ | 50% | 75% | 100% |

## Тав. Гэрээний хугацаа, гэрээ байгуулах, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг дүгнэх, цуцлах.

### 5.1. Гэрээний хугацаа

5.1.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж, мөрдөх бөгөөд 2014 оны ..... /дугаар, дүгээр/ сарын ..... /-ны, ний/ өдрөөс 2015 оны ..... /дугаар, дүгээр/ сарын ..... /-ны, ний/ өдөр хүртэл 1 жилийн хугацаатай байна.

### 5.2. Гэрээ байгуулах

5.2.1. Худалдан авагч нь халаалтын улирал эхлэхийн өмнө дулааны эрчим хүч авах болон хаах хугацаа, хэрэглэх эрчим хүчний тоо хэмжээ, дулааны шугам, тоног төхөөрөмжид хийсэн засвар үйлчилгээ, угаалт, шахалтыг хийж, техникийн найдвартай байдлыг хангасан тухай баталгаа гарган, албан бичгээр хүсэлт гаргаж худалдагч талд өгснөөр дулааны эрчим хүч худалдан авах нөхцөл бүрдэнэ.

5.2.2. Дулааны эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулах хэрэглэгч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Дулааны эрчим хүч хэрэглэх техникийн нөхцөл авсан байх;
2. Дулааны эрчим хүчний төлбөрөө бүрэн барагдуулсан байх;
3. Дулааны шугам сүлжээ, тоноглолд хийх засвар үйлчилгээг зохих журмын дагуу хийж, аюулгүй, найдвартай байдлыг хангасан байх;
4. Дулааны шугамын заагийн зургийг баталгаажуулсан байх ба хугацаа дууссан бол сунгалт хийлгэсэн байх;
5. Дулааны шугам сүлжээний хамгаалалтын зурваст хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулаагүй байна.
6. Дулааны шугам сүлжээний хамгаалалтын зурваст хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулаагүй байна.

5.2.3. Энэхүү гэрээнд дараах баримт бичгийг хавсаргах бөгөөд тэдгээр нь гэрээний салшгүй хэсэг байна. Үүнд:

1. Худалдан авагч талын дулааны шугамын холболт, тоолуурын байрлал, эзэмшлийн заагийн схем зураг;
2. Дулааны тоолуур, хэмжих, тохируулах хэрэгсэл суурилуулсан, тооцоонд хүлээн авсан тухай протокол, акт;



4.5.7. Хэрэв хэрэглэгч бэлнээр тооцоог хийх бол банкин дахь худалдагчийн дансанд эсвэл бэлэн мөнгөний кассанд биечлэн тушааж, мөнгө тушаасан баримтыг авч хадгална. */Гуравдагч этгээдээр дамжуулан тушаасан мөнгөтэй холбогдсон маргаантай асуудлыг* худалдагч тал хариуцахгүй/.

4.6. Талуудын хооронд тавигдах нэмэлт ба нөхөн төлбөр, торгууль, хохирлын нэхэмжлэлийг тушаахдаа талууд хамтран тогтоосон актыг үндэслэн гүйцэтгэнэ.

4.7. Талууд жилд 2-оос доошгүй удаа дулааны эрчим хүчний борлуулалтын төлбөрийн талаар тооцоо нийлж, акт үйлдэх бөгөөд жил бүрийн халаалтын улирал дуусахад хангагч талын "Төлбөр тавилтын түүх"-ийг үндэслэн гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулна.

4.8. Худалдан авагч нь тухайн сарын дулааны төлбөрийг дараах хуваарийн дагуу төлж барагдуулна.

*Хүснэгт №2*

| Төлбөр төлөх хугацаа | Сар бүрийн | | |
|---|---|---|---|
| | 15-ны дотор | 20-ны дотор | 25-ны дотор |
| Төлөх хэмжээ | 50% | 75% | 100% |

### Тав. Гэрээний хугацаа, гэрээ байгуулах, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг дүгнэх, цуцлах.

### 5.1. Гэрээний хугацаа

5.1.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж, мөрдөх бөгөөд 2014 оны 10 /дугаар, дүгээр/ сарын 01 /-ны, ний/ өдрөөс 2015 оны 05 /дугаар, дүгээр/ сарын 15 /-ны, ний/ өдөр хүртэл 1 жилийн хугацаатай байна.

### 5.2. Гэрээ байгуулах

5.2.1. Худалдан авагч нь халаалтын улирал эхлэхийн өмнө дулааны эрчим хүч авах болон хаах хугацаа, хэрэглэх эрчим хүчний тоо хэмжээ, дулааны шугам, тоног төхөөрөмжид хийсэн засвар үйлчилгээ, угаалт, шахалтыг хийж, техникийн найдвартай байдлыг хангасан тухай баталгаа гарган, албан бичгээр хүсэлт гаргаж худалдагч талд өгснөөр дулааны эрчим хүч худалдан авах нөхцөл бүрдэнэ.

5.2.2. Дулааны эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулах хэрэглэгч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Дулааны эрчим хүч хэрэглэх техникийн нөхцөл авсан байх;
2. Дулааны эрчим хүчний төлбөрөө бүрэн барагдуулсан байх;
3. Дулааны шугам сүлжээ, тоноглолд хийх засвар үйлчилгээг зохих журмын дагуу хийж, аюулгүй, найдвартай байдлыг хангасан байх;
4. Дулааны шугамын заагийн зургийг баталгаажуулсан байх ба хугацаа дууссан бол сунгалт хийлгэсэн байх;
5. Дулааны шугам сүлжээний хамгаалалтын зурваст хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулаагүй байна.
6. Дулааны шугам сүлжээний хамгаалалтын зурваст хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулаагүй байна.

5.2.3. Энэхүү гэрээнд дараах баримт бичгийг хавсаргах бөгөөд тэдгээр нь гэрээний салшгүй хэсэг байна. Үүнд:

1. Худалдан авагч талын дулааны шугамын холболт, тоолуурын байрлал, эзэмшлийн заагийн схем зураг;
2. Дулааны тоолуур, хэмжих, тохируулах хэрэгсэл суурилуулсан, тооцоонд хүлээн авсан тухай протокол, акт;



3. Гэрээний эх үүсвэрийн дэлгэрэнгүй мэдээлэл; хүснэгт №1
4. Дулааны эрчим хүчний өр төлбөрийг төлөх график, хугацаа; хүснэгт №2
5. Гэрээ дүгнэсэн тухай акт, протокол;
6. Худалдан авагч талын аж ахуйн нэгжийн болон үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн гэрчилгээ, иргэний цахим үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хуулбар хувь, барилгын гадна фото зураг байна.

5.2.4. Худалдан авагч тал барилга объектоо худалдах буюу бусдын эзэмшилд шилжүүлэхдээ худалдагч талд албан бичгээр урьдчилан мэдэгдэж, төлбөр тооцоог бүрэн дуусгана.

5.2.5. Гэрээ байгуулах, дүгнэх, сунгахтай холбогдсон бичиг хэргийн зардлыг худалдан авагч тал тухай бүр хариуцан төлнө.

5.2.6. Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болох ба 2 хувь үйлдэж, талууд хувийг нэгэн адил хадгална.

### 5.3. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах

5.3.1. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд зөвхөн бичгээр нэмэлт өөрчлөлт оруулах ба энэ тухай саналаа 15 хоногийн өмнө нөгөө талд бичгээр гаргана.

5.3.2. Гэрээнд өөрчлөлт оруулахдаа нэмэлт өөрчлөлтийг тодорхой бичиж гарын үсэг зуран, тамга дарж баталгаажуулснаар энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй болох бөгөөд гэрээний салшгүй хэсэг байна.

### 5.4. Гэрээний биелэлтийг дүгнэх

5.4.1. Энэхүү гэрээний биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнэх бөгөөд “Гэрээ дүгнэх акт”-нд талууд гарын үсэг зуран, тамга дарж

албажуулснаар хүчин төгөлдөр болно.

5.4.2. Хэрэв худалдан авагч тал гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж дүгнэгдвэл худалдагч тал дулааны эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлэх, улмаар эрчим хүч худалдах худалдан авах гэрээг худалдагч талын санаачлагаар цуцлах үндэслэл болно.

5.4.3. "Гэрээ дүгнэх акт"-ыг 2 хувь үйлдэж, талууд нэгэн адил хадгална.

### 5.5. Гэрээг цуцлах

5.5.1. Дараах тохиолдолд гэрээг цуцлана. Үүнд:

1. Худалдан авагч тал дулааны эрчим хүчний төлбөрийг худалдагч талын нэхэмжилсэн хугацаанд удаа дараа төлөөгүйгээс өр төлбөр үүсгэсэн хэрэглэгчид Иргэний хуулийн 225 дугаар зүйлийн 225.1-д заасны дагуу үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч үр дүн гараагүй;
2. Хэрэглэгч нь техникийн хувьд өөрийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа дулааны шугам, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг бүрэн хийж гүйцэтгээгүйгээс худалдагч талд болон төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон бусад хэрэглэгчдэд хохирол учруулсан;
3. Худалдан авагч нь дулааны шугамын хамгаалалтын зурвасын хилийн зааг дотор худалдагч талын зөвшөөрснөөс бусад хууль бус үйл ажиллагаа явуулсан, гэрээний 3.2.14-д заасан хориглосон үйл ажиллагаа явуулсан;
4. Худалдан авагч нь Эрчим хүчний тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.7, 29.1.8, 32 дугаар зүйл, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрмийн 54 дүгээр хэсэг болон гэрээний үүргээ ноцтойгоор зөрчсөн тохиолдолд, мөн түүнчлэн гэрээ дүгнэх актад гэрээний үүргийн биелэлт хангалтгүй, цаашид дулааны эрчим хүчээр хангах боломжгүй гэж тогтоосон зэрэг шалтгаанаар уул гэрээг цуцлана.



5.5.2. Дээрх үндэслэлээр худалдан авагч дулааны эрчим хүчээр хангахаас татгалзаж, уул гэрээг цуцлаж болох ба үүнтэй холбогдон гарах аливаа хохирлыг худалдан авагч бүрэн хариуцна. Эдгээрээс өөр шалтгаанаар хангагч талын санаачлагаар гэрээг цуцлахыг хориглоно.

### Зургаа. Харилцан хүлээх хариуцлага, маргааныг шийдвэрлэх

6.1. Худалдагч талаас худалдан авагч талд гэрээний үүргийн биелэлттэй холбоотой ирүүлсэн "Албан шаардлага"-ын хугацаанд худалдан авагч зөрчлөө арилгаагүй тохиолдолд гэрээг цуцлаж, эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлэх тухай "Албан мэдэгдэл"-ийг өгөх ба гардуулан өгсөн өдрөөс хойш 3 хоногийн дараа таслалтыг гүйцэтгэнэ.

6.2. Гэрээг дүгнэхэд худалдан авагчийн "Дулаан хангамжийг түдгэлзүүлэх" тухай шийдвэр гарсан бол худалдан авагчийн дулааны хэрэглээг хязгаарлах ба албан мэдэгдэлд хязгаарлалт хийх хугацааг тодорхой зааж, 3-аас доошгүй хоногийн өмнө гэрээ дүгнэсэн протокол шийдвэрийн хамт худалдагч тал худалдан авагч талд хүргүүлнэ.

6.3. Худалдагч талын эрх бүхий ажилтан ажлын шаардлагаар хэрэглэгчийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжид үзлэг шалгалт, тохируулга хийх явцдаа хэрэглэгчид хохирол учруулсан бол хохирлыг худалдагч тал нөхөн төлнө.

6.4. Энэхүү гэрээг байгуулах, хэрэгжүүлэх явцад талуудын хооронд гэрээний үүргийн биелэлт, төлбөр тооцооны талаар маргаантай асуудал гарвал зөвшилцлийн аргаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч эс чадвал Эрчим хүчний зохицуулах хороо болон шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

## Долоо. Бусад

7.1. Гэрээний заалт хууль тогтоомжийн заалттай зөрчилдвөл, талууд хууль тогтоомжийн заалтыг баримтлах ба уул гэрээнд тусгагдаагүй харилцаа үүсвэл холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд уг харилцааг зохицуулна.

7.2. Талууд гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болж, уг гэрээнд заасан хугацаанд үйлчилнэ.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ХУДАЛДАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
(Албан тушаал, нэр)
Дулааны үйлчилгээний
3... салбарын дарга
......... /Д. Бөртогтох
/Гарын үсэг, нэрийн тайлал/

ХУДАЛДАН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
(Албан тушаал, нэр)
ЗОСҮТ-ийн ААҮТ-ийн эрхлэгч
......... , С. Болорзаяа
/Гарын үсэг, нэрийн тайлал/



### Худалдагч талын мэдээлэл

Нэр: Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК.
Хаяг: БГД-ийн 3 дугаар хороо, Энгельсийн гудамж
Вэб сайт: www.ubds.energy.mn
Утасны дугаар: 11-343047, 77-342397
Электрон шуудангийн хаяг: dhsub@ubds.energy.mn
Факсын дугаар: 11-342397
Банкны харилцах данс

| Банкны нэр | Харилцах дансны дугаар |
|---|---|
| Төрийн сан | 900000953 |
| Төрийн банк | 241800119907 |
| Төрийн банк | 105400009366 |
| Төрийн банк | 101400016172 |
| Худалдаа хөгжлийн банк | 406001016 |
| Худалдаа хөгжлийн банк | 406005907 |
| Голомт банк | 1102016521 |
| Капитал банк | 2000001217 |
| Улаанбаатар банк | 2603001347 |
| Хаан банк | 5023141406 |
| Хас банк | 5000724006 |

### Худалдан авагч талын мэдээлэл

Нэр: ЗОСҮТ.
Хаяг: СХД-ийн 20-р хороо.
Банкны нэр: Төрийн сан банк.
Харилцах дансны дугаар: 900020021.
Утасны дугаар: 70282859.
Электрон шуудангийн хаяг: ..........
Факсын дугаар: 70282859.

БАТЛАВ.
УЛААНБААТАР ДУЛААНЫ
СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Р.ХАЙДАВ

............................................................
/Гарын үсэг, тамга/

БАТЛАВ.

______________________________
______________________________
______________________________

............................................................
/Гарын үсэг, тамга/

**Дулааны эрчим хүч худалдах, худалдан авах тухай ...........**
**тоот гэрээний эх үүсвэрт оруулсан нэмэлт өөрчлөлт**

Худалдагч, худалдан авагч талын 20 .... оны .....-р сарын ......-ны өдрийн ...... дугаар бүхий албан бичиг, .................................................. ...................................... зэргийг үндэслэн 20 .... оны .....-р сарын ......-ны өдрөөс эхлэн дараах өөрчлөлтийг гэрээнд тусгав.

*20 ... оны .... дугаар сарын ....-ны өдөр*

| Барилга объектын нэр | Халаалт | | | Хэрэгцээний халуун ус | | | Салхивч /Гкал/ | Дулааны тоолуур-тай эсэх | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Эзэлхүүн /м³/ | Орон сууцны талбай /м²/ | Подвал /м²/ | Албаны /хүнэгр/ | Орон сууц /хүнэгр/ | ХХУ | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| Нийт | | | | | | | | | | |

ХУДАЛДАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
(Албан тушаал, нэр)
*Дулааны үйлчилгээний*
*..... салбарын дарга*

................................ /                    /
/Гарын үсэг, нэрийн тайлал/

ХУДАЛДАН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
(Албан тушаал, нэр)
______________________________
______________________________

................................ /                    /
/Гарын үсэг, нэрийн тайлал/



**Худалдагч талын мэдээлэл**

Нэр: Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК.
Хаяг: БГД-ийн 3 дугаар хороо, Энгельсийн гудамж
Вэб сайт: www.ubds.energy.mn
Утасны дугаар: 11-343047, 77-342397
Электрон шуудангийн хаяг: dhsub@ubds.energy.mn
Факсын дугаар: 11-342397
Банкны харилцах данс

| Банкны нэр | Харилцах дансны дугаар |
|---|---|
| Төрийн сан | 900000953 |
| Төрийн банк | 241800119907 |
| Төрийн банк | 105400009366 |
| Төрийн банк | 101400016172 |
| Худалдаа хөгжлийн банк | 406001016 |
| Худалдаа хөгжлийн банк | 406005907 |
| Голомт банк | 1102016521 |
| Капитал банк | 2000001217 |
| Улаанбаатар банк | 2603001347 |
| Хаан банк | 5023141406 |
| Хас банк | 5000724006 |

**Худалдан авагч талын мэдээлэл**

Нэр: ..........................................................................................................
Хаяг: ..........................................................................................................
Банкны нэр: ..............................................................................................
Харилцах дансны дугаар: ..........................................................................
Утасны дугаар: ..........................................................................................
Электрон шуудангийн хаяг: .......................................................................
Факсын дугаар: ..........................................................................................

БАТЛАВ.
УЛААНБААТАР ДУЛААНЫ
СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Р.ХАЙДАВ

..........................................................
/Гарын үсэг, тамга/

БАТЛАВ.

______________________________
______________________________
______________________________

..........................................................
/Гарын үсэг, тамга/

**Дулааны эрчим хүч худалдах, худалдан авах тухай ...........
тоот гэрээний эх үүсвэрт оруулсан нэмэлт өөрчлөлт**

Худалдагч, худалдан авагч талын 20 .... оны .....-р сарын ......-ны өдрийн ...... дугаар бүхий албан бичиг, .................................................. ..................................... зэргийг үндэслэн 20 .... оны .....-р сарын ......-ны өдрөөс эхлэн дараах өөрчлөлтийг гэрээнд тусгав.

*20 ... оны .... дугаар сарын ....-ны өдөр*

| Барилга объектын нэр | Халаалт | | | Хэрэгцээний халуун ус | | | Салхивч /Гкал/ | Дулааны тоолуур-тай эсэх | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Эзэлхүүн /м³/ | Орон сууцны талбай /м²/ | Подвал /м²/ | Албаны /хүнээр/ | Орон сууц /хүнээр/ | ХХУ | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| Нийт | | | | | | | | | | |

ХУДАЛДАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
(Албан тушаал, нэр)
*Дулааны үйлчилгээний*
*..... салбарын дарга*

................................ / /
/Гарын үсэг, нэрийн тайлал/

ХУДАЛДАН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
(Албан тушаал, нэр)
______________________________
______________________________

................................ / /
/Гарын үсэг, нэрийн тайлал/



БАТЛАВ.
УЛААНБААТАР ДУЛААНЫ
СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Р.ХАЙДАВ

..........................................................
/Гарын үсэг, тамга/

БАТЛАВ.

______________________________
______________________________
______________________________

..........................................................
/Гарын үсэг, тамга/

**Дулааны эрчим хүч худалдах, худалдан авах тухай ...........
тоот гэрээний эх үүсвэрт оруулсан нэмэлт өөрчлөлт**

Худалдагч, худалдан авагч талын 20 .... оны .....-р сарын ......-ны өдрийн ...... дугаар бүхий албан бичиг, .................................................. ..................................... зэргийг үндэслэн 20 .... оны .....-р сарын ......-ны өдрөөс эхлэн дараах өөрчлөлтийг гэрээнд тусгав.

*20 ... оны .... дугаар сарын ....-ны өдөр*

| Барилга объектын нэр | Халаалт | | | Хэрэгцээний халуун ус | | | Салхивч /Гкал/ | Дулааны тоолуур-тай эсэх | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Эзэлхүүн /м³/ | Орон сууцны талбай /м²/ | Подвал /м²/ | Албаны /хүнээр/ | Орон сууц /хүнээр/ | ХХУ | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| Нийт | | | | | | | | | | |

ХУДАЛДАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
(Албан тушаал, нэр)
*Дулааны үйлчилгээний*
*..... салбарын дарга*

................................ / /
/Гарын үсэг, нэрийн тайлал/

ХУДАЛДАН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
(Албан тушаал, нэр)
______________________________
______________________________

................................ / /
/Гарын үсэг, нэрийн тайлал/

БАТЛАВ.
УЛААНБААТАР ДУЛААНЫ
СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Р.ХАЙДАВ

.........................................................
/Гарын үсэг, тамга/

БАТЛАВ.

.........................................................
/Гарын үсэг, тамга/

**Дулааны эрчим хүч худалдах, худалдан авах тухай ........... тоот гэрээний эх үүсвэрт оруулсан нэмэлт өөрчлөлт**

Худалдагч, худалдан авагч талын 20 .... оны .....-р сарын ......-ны өдрийн ...... дугаар бүхий албан бичиг, ................................................ .................................... зэргийг үндэслэн 20 .... оны .....-р сарын ......-ны өдрөөс эхлэн дараах өөрчлөлтийг гэрээнд тусгав.

*20 ... оны .... дугаар сарын ....-ны өдөр*

| Барилга объектын нэр | Халаалт | | | Хэрэгцээний халуун ус | | | Салхивч /Гкал/ | Дулааны тоолуур-тай эсэх | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Эзэлхүүн /м$^3$/ | Орон сууцны талбай /м$^2$/ | Подвал /м$^2$/ | Албаны /хүнээр/ | Орон сууц /хүнээр/ | ХХУ | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| Нийт | | | | | | | | | | |

ХУДАЛДАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
(Албан тушаал, нэр)
*Дулааны үйлчилгээний*
*..... салбарын дарга*
.............................. / /
/Гарын үсэг, нэрийн тайлал/

ХУДАЛДАН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
(Албан тушаал, нэр)

.............................. / /
/Гарын үсэг, нэрийн тайлал/



БАТЛАВ.
УЛААНБААТАР ДУЛААНЫ
СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Р.ХАЙДАВ

.........................................................
/Гарын үсэг, тамга/

БАТЛАВ.
Зооноргын Өвчин Судлалын
Үндэсний Төв-н
захирал

.........................................................
/Гарын үсэг, тамга/

**Дулааны эрчим хүч худалдах, худалдан авах тухай 872 тоот гэрээний сунгалт**

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Зооноргын Ө С Ч Төв -ийн хооронд 20 15 оны 872 тоот гэрээг дүгнэсэн актыг үндэслэн, уг гэрээг 20 15 оны 10-р сарын 01-ний өдрөөс 20 16 оны 05-р сарын 01-ны өдөр хүртэл хугацаагаар сунгав.

*20 ... оны .... дугаар сарын ....-ны өдөр*

| Барилга объектын нэр | Халаалт | | | Хэрэгцээний халуун ус | | | Салхивч /Гкал/ | Дулааны тоолуур-тай эсэх |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Эзэлхүүн /м$^3$/ | Орон сууцны талбай /м$^2$/ | Подвал /м$^2$/ | Албаны /хүнээр/ | Орон сууц /хүнээр/ | ХХУ | | |
| ЗӨСЧТөв. | 14051,4 | | | | | 99.9 | | № 1655 |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Нийт | 14051,4 | | | | | 99.9 | | |

ХУДАЛДАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
(Албан тушаал, нэр)
*Дулааны үйлчилгээний*
*I салбарын дарга*
.............................. / Д. Баярбаатар
/Гарын үсэг, нэрийн тайлал/

ХУДАЛДАН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
(Албан тушаал, нэр)

.............................. / Бүрэнжаргал
/Гарын үсэг, нэрийн тайлал/

БАТЛАВ.
УЛААНБААТАР ДУЛААНЫ
СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Р.ХАЙДАВ

........................................................
/Гарын үсэг, тамга/

УЛААНБААТАР ХОТ УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ ТӨХК ТТБ3132 2688476

БАТЛАВ.
[illegible] захирал

........................................................
/Гарын үсэг, тамга/

## ГЭРЭЭНД ОРУУЛСАН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

*20 ... оны .... дугаар сарын ....-ны өдөр*

хэрэглэгч нь Монгол улсын "Эрчим хүчний тухай" хууль 2015.6.19-ний өдөр өөрчлөн найруулсан болон нэмэлт [illegible] дагаж мөрдөнө.

Худалдагч, худалдан авагч талын 20 .... оны .....-р сарын ......-ны өдрийн ...... дугаар бүхий албан бичиг, ................................................ ................................................ зэргийг үндэслэн 20 .... оны ....-р сарын ....-ны өдрөөс эхлэн гэрээний үүсвэрт дараах өөрчлөлтийг тусгав.



*20 ... оны .... дугаар сарын ....-ны өдөр*

| Барилга объектын нэр | Халаалт | | | Хэрэгцээний халуун ус | | | Салхивч /Гкал/ | Дулааны тоолуур-тай эсэх | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Эзэлхүүн /м³/ | Орон сууцны талбай /м²/ | Подвал /м²/ | Албаны /хүнээр/ | Орон сууц /хүнээр/ | ХХУ | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| Нийт | | | | | | | | | | |

ХУДАЛДАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
(Албан тушаал, нэр)
*Дулааны үйлчилгээний*
*..... салбарын дарга*
................................ / /
/Гарын үсэг, нэрийн тайлал/

ХУДАЛДАН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
(Албан тушаал, нэр)
________________________
________________________
................................ / /
/Гарын үсэг, нэрийн тайлал/

*20 ... оны .... дугаар сарын ....-ны өдөр*

| Барилга объектын нэр | Халаалт | | | Хэрэгцээний халуун ус | | | Салхивч /Гкал/ | Дулааны тоолуур-тай эсэх | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Эзэлхүүн /м³/ | Орон сууцны талбай /м²/ | Подвал /м²/ | Албаны /хүнээр/ | Орон сууц /хүнээр/ | ХХУ | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| Нийт | | | | | | | | | | |

ХУДАЛДАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
(Албан тушаал, нэр)
*Дулааны үйлчилгээний*
*..... салбарын дарга*

................................ / /
/Гарын үсэг, нэрийн тайлал/

ХУДАЛДАН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
(Албан тушаал, нэр)
________________________
________________________

................................ / /
/Гарын үсэг, нэрийн тайлал/



ТЭМДЭГЛЭЛ

БАТЛАВ.
УЛААНБААТАР ДУЛААНЫ
СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Р.ХАЙДАВ

.........................................................
/Гарын үсэг, тамга/

БАТЛАВ.

.........................................................
/Гарын үсэг, тамга/

**Дулааны эрчим хүч худалдах, худалдан авах тухай**
**......... тоот гэрээний сунгалт**

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, ............................................. -ийн хооронд 20.... оны ......... тоот гэрээг дүгнэсэн актыг үндэслэн, уг гэрээг 20.... оны ....-р сарын ....-ний өдрөөс 20.... оны ....-р сарын ....-ны өдөр хүртэл хугацаагаар сунгав.

*20 ... оны .... дугаар сарын ....-ны өдөр*

| Барилга объектын нэр | Халаалт | | | Хэрэгцээний халуун ус | | | Салхивч /Гкал/ | Дулааны тоолуур-тай эсэх |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Эзэлхүүн /м³/ | Орон сууцны талбай /м²/ | Подвал /м²/ | Албаны /хүнэзр/ | Орон сууц /хүнэзр/ | ХХУ | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Нийт | | | | | | | | |

ХУДАЛДАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
(Албан тушаал, нэр)
*Дулааны үйлчилгээний*
*..... салбарын дарга*

................................ / /
/Гарын үсэг, нэрийн тайлал/

ХУДАЛДАН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
(Албан тушаал, нэр)

................................ / /
/Гарын үсэг, нэрийн тайлал/



БАТЛАВ.
УЛААНБААТАР ДУЛААНЫ
СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Р.ХАЙДАВ

.........................................................
/Гарын үсэг, тамга/

БАТЛАВ.

.........................................................
/Гарын үсэг, тамга/

ГЭРЭЭНД ОРУУЛСАН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

*20 ... оны .... дугаар сарын ....-ны өдөр*

........................................................................................................................
........................................................................................................................
........................................................................................................................
........................................................................................................................
........................................................................................................................
........................................................................................................................
........................................................................................................................
........................................................................................................................
........................................................................................................................
........................................................................................................................
........................................................................................................................
........................................................................................................................
........................................................................................................................
........................................................................................................................
........................................................................................................................
........................................................................................................................

Худалдагч, худалдан авагч талын 20 .... оны .....-р сарын ......-ны өдрийн ...... дугаар бүхий албан бичиг, ........................................................ ........................................................................................................................ .............................. зэргийг үндэслэн 20 .... оны ....-р сарын ....-ны өдрөөс эхлэн гэрээний үүсвэрт дараах өөрчлөлтийг тусгав.